



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/523

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Нийтийн эзэмшлийн талбайд тарих зүлэгний үр, цэцэгний үр нийлүүлэх, Нийтийн эзэмшлийн талбайд гоёлын модны суулгац нийлүүлэх ажлуудын гүйцэтгэгч “Сутайн цамхаг” ХХК-ийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Л.Батгэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Пүрэвдорж - Хот тохижуулах газрын дарга

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Б.Баяржавхлан - Жаргалант сумын байгаль орчны улсын байцаагч

Н.Энхболд - “Сутайн цамхаг” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Бөхболд - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

2. Нийтийн эзэмшлийн талбайд тарих зүлэгний үр, цэцэгний үр нийлүүлэх, Нийтийн эзэмшлийн талбайд гоёлын модны суулгац нийлүүлэх ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Г.ЖАРГАЛСАЙХАН

02 2740 Zah A/523 Kh